МУЗЗНДН түүний удирдлагын тухай хууль
сурталчилсан тухай илтгэх хуудас

2014.11.07 Сэлэнгэ сум

Сумын ИТХ-ын даргын удирдамжийн дагуу өвөл цагийн хүмүүжлийн ажлын нээлт болгож Нутгийн өөрөө удирдах байгууллагын хэрэгжүүлэх эрх үүрэг болон сумын ИТХ-ын





тэргүүлэгчдийн хийсэн ажлын мэдээлэл, багуудын ИНХ-ын дарга нарын хийсэн ажлын мэдээлэл тус бүрийг танилцуулав. ИТХ-ын дарга нээж үг хэлэв. ИТХ-ын нарийн бичгийн дарга ИТХ-ын танилцуулга, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийн болон тэргүүлэгчийн бүрэн эрх, баг хорооны ИНХ-ын дарга нарын бүрэн эрхээр сургалт хийлээ. Сургалтанд сумын ИТХ-ын төлөөлөгчид, тэргүүлэгчид, багуудын ИНХ-ын дарга , иргэдийн төлөөлөл 50 гаруй хүмүүс оролцов. Мөн сумын ИТХ-ын тэргүүлэгчдээс 2014 онд хийсэн ажлын тайлан, багуудын





ИНХ-ын дарга нарын тайланг танилцуулж санал хүсэлтийг нь сонслоо. Дараа нь хурлын даргын санаачлагаар иргэдийн дунд азын сугалаа зохион байгуулж 5-р багийн иргэн Т.Баттулга, С.Цогтсайхан нар азтан боллоо. Мөн заасан хуулийн чиглэлээр АХА зохион байгуулан түрүүлсэн 2 иргэнийг урамшуулсан нь иргэдийн сайшаалыг төрүүлсэн ажил байв. Энэ удирдамжаар хөдөөгийн 2,3,4-р багуудад ажиллах ажлын хэсгийн томилон ажиллахаар боллоо.